



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ**

2012 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А-74

Улаанбаатар хот


Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.11.3, 4.17.6, Ректорын зөвлөлийн 2011 оны 6 дугаар  
28, 2011 оны 11 дүгээр сарын 01, 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн  
тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн журам”-ыг нэгдүгээр  
саралтаар, “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн нийтлэг журам”-ыг  
дугаар хавсралтаар тус тус баталж, 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн  
ж мөрдсүгэй.


2. Энэ тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1999  
10 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар батлагдсан “ШУТИС-д Эрдэм  
шилгээний хүрээлэн, эрдэм шинжилгээний төв байгуулах журам” -ыг 2012 оны 3  
сарын 27-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмыг мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ,  
технологийн проректор /Б.Очирбат/, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвийн  
орлуудад үүрэг болгосугай.



РЕКТОР

Б.ДАМДИНСҮРЭН



ШУТИС-ийн Ректорын 2012 оны 7-р сарын 24-ны өдрийн Дугаар тоот тушаалын хоёрдугаар хавсралт

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТӨВИЙН НИЙТЛЭГ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, ШУТИС-ийн дүрмийг мөрдөн тус их сургуульд Эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, туршилтын төв байгуулж байгуулах, түүний үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлох, түүнтэй холбогдон үүсэх шаардлагаг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, судалгаа бүтээх ажил эрхлэх, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, их сургуульд туршилтын хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи дамжуулах зорилготой ажил хэрэгтэй чиглэлийн эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, туршилтын төв (цаашид төв гэнэ)-ийг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнг түшиглэн эрдэм шинжилгээний нэгж байгуулж ажиллуулна.

1.3. Төв нь улсын болон бизнесийн байгууллагын захиалгат төсөл, гэрээт ажил болон бусадтай хамтарсан эрдэм шинжилгээний төсөл, судалгааны гэрээт ажил гүйцэтгэх, үргэлжлүүлэх сургалт явуулах, инноваци, технологи дамжуулалтыг хөгжүүлэх зорилго бүхий ажил байна.

### Хоёр. Төв байгуулах

2.1. ШУТИС-ийн захиргаа, нэгж байгууллагууд болон багш, судлаачдын (цаашид төв байгуулагч гэх) санаачилгаар бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнг түшиглэн төв байгуулж ажиллуулна.

2.2. Үүсгэн байгуулагч төв байгуулах үндэслэл, санал, хүсэлтээ холбогдох шаардлага бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдэмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжсэн шийдвэр, энэхүү нийтлэг журамд нийцүүлэн боловсруулсан төвийн дүрмийн төслийн хамт их сургуулийн Инноваци, технологи дамжуулалтын алба (цаашид ИТДА гэх)-нд ирүүлэх ба төв байгуулах асуудлыг ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

2.3. Төвийн үйл ажиллагааны дүрмийг Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, ректорын тушаалаар баталгаажуулах бөгөөд шинээр байгуулагдсан төвд ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний нэгж байгууллагын бүртгэлийн гэрчилгээг 2 жилийн хугацаатайгаар олгоно.

2.4. Төвийн гэрчилгээ дээр төвийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулсан шийдвэр, огноо, хүчинтэй хугацааг тэмдэглэж их сургуулийн Ректор гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд эрдэм шинжилгээ, технологийн проректор гэрчилгээний хүчинтэй хугацааг 2 жилээр сунгаж гарын үсэг зурна.

### Гурав. Төвийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Төвийн захирлыг ШУТИС-ийн ректор, холбогдох бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн удирдлагатай зөвшилцөн 2 жилийн хугацаатайгаар томилох ба дахин 2 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн ажиллуулж болно.